



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 09 сарын 08 өдөр

Дугаар 441

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2, 6.3.4, 6.4.3, 6.4.4, 8 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 19,911,949.00 (арван есөн сая есөн зуун арван нэгэн мянга есөн зуун дөчин есөн) төгрөгийн балансын үнэ, 650,281.00 (зургаан зуун тавин мянга хоёр зуун наян нэгэн) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Насантогтох, “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Д.Баярсайхан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Компанийн өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан дэд өртөөний барилгыг иргэн Ш.Чулуунцэцэгийн хөрөнгөөр буулгаж, зөөн шилжүүлэх, үлдэгдэл өртгийг төлүүлэх, ашиглаж буй тоноглолуудыг хүлээн авах, шинээр барих дэд өртөөний барилга болон шинэ тоноглолуудыг компанийн үндсэн хөрөнгөд бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу няглан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийн хамт 2020 оны 3 дугаар улиралд багтаан тайлагнах.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА 
Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА  Д.НАРАНГЭРЭЛ

300782

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны ~~09~~⁰⁸-дугаар сарын ~~08~~⁰⁹-ны өдрийн
~~44~~⁴⁵ дугаар тогтоолын хавсралт

"УЛААНБААТАР ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, АКТАЛЖ, ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Балансын үнэ (төгрөг)	Хуrimтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Цахилгааны дэд өртөө, ХТП-087 /Хан-Уул дүүрэг/, тм 630 кВА, 6/0.4 кв	1975	ш	1	19,911,949.00	650,281.00	19,261,668.00
Нийт дүн					19,911,949.00 (арван есөн сая есөн зуун арван нэгэн мянга есөн зуун дөчин есөн)	650,281.00 (зургаан зуун тавин мянга хоёр зуун наян нэгэн)	19,261,668.00 (арван есөн сая хоёр зуун жаран нэгэн мянга зургаан зуун жаран найман)